



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ
ТЭМДЭГЛЭЛЭЭС**

2024 оны 02 сарын 06 өдөр

Дугаар 05

Улаанбаатар хот

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2024 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн хуралдааны 4 дүгээр тэмдэглэлд:

ҮҮ.12.ХЭЛЭЛЦСЭН нь: Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
Төрийн өмчийн хяналт шалгалтын хэлтсээс
хийсэн гүйцэтгэлийн шалгалтын тухай

ШИЙДВЭРЛЭСЭН нь:

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 66 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.1 дэх хэсэг, мөн Төрийн өмчийн хяналт шалгалтын хэлтсийн 2023 оны гүйцэтгэлийн шалгалтын төлөвлөгөөний дагуу "Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай" тогтоолын биелэлтийг хангуулах зорилгоор доорх төрийн өмчит 10 хуулийн этгээдэд гүйцэтгэлийн хяналт шалгалт хийв.

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан хяналт-шинжилгээ, үнэлгээний аргачлалын дагуу үнэлэхэд 5 байгууллага "Бүрэн хэрэгжсэн", 5 байгууллага "Хэрэгжих шатанд" буюу дундаж үнэлгээ 89 хувь байгаа тухай танилцуулав.

Д/д	Хуулийн этгээдийн нэр	Тогтоолын огноо/ дугаар	Арга хэмжээ	Гүйцэтгэлийн шалгалтын үнэлгээ/хувь	Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан хяналт-шинжилгээ, үнэлгээний аргачлалын дагуу хүрсэн түвшин
1	"Дорнод бүсийн эрчим хүчний систем" ТӨХК	2022/31	11/10	91%	Бүрэн хэрэгжсэн
2	"Төв АЗЗА" ТӨХК	2022/226	10/10	100%	Бүрэн хэрэгжсэн
3	"Монголросцветмет" ТӨҮГ	2023/32	13/13	95%	Бүрэн хэрэгжсэн
4	"Говь-Алтай АЗЗА" ТӨХК	2023/42	5/5	100%	Бүрэн хэрэгжсэн
5	"Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар" ТӨҮГ	2023/47	6/6	100%	Бүрэн хэрэгжсэн

6	"Өвөрхангай АЗЗА" ТӨХК	2022/282	13/11	85%	Хэрэгжих шатанд
7	"Монгол кино нэгтгэл" ТӨҮГ	2022/332	9/7	78%	Хэрэгжих шатанд
8	"Талын зам" ТӨХК	2022/333	9/7	78%	Хэрэгжих шатанд
9	"Эрдэнэсант АЗЗА" ТӨХК	2022/334	10/9	88%	Хэрэгжих шатанд
10	"Багануур АЗЗА" ТӨХК	2022/398	5/4	80%	Хэрэгжих шатанд
Үнэлгээний дундаж дүн			91/82	89%	

Цаашид шалгалтын мөрөөр авах арга хэмжээг эрчимжүүлж, тогтоолын бүрэн хэрэгжээгүй зарим заалтын биелэлтийг ханган ажиллах, тогтоолын биелэлтийг гаргахдаа тоо баримтад тулгуурлан цаг хугацаанд нь үнэн зөв гаргаж ирүүлэхийг гүйцэтгэлийн шалгалтад хамрагдсан “Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК, “Төв АЗЗА” ТӨХК, “Өвөрхангай АЗЗА” ТӨХК, “Монгол кино” ТӨҮГ, “Талын зам” ТӨХК, “Эрдэнэсант АЗЗА” ТӨХК, “Багануур АЗЗА” ТӨХК, “Говь-Алтай АЗЗА” ТӨХК, “Монголросцветмет” ТӨҮГ, “Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” ТӨҮГ-ын удирдлагуудад үүрэг болгов. гэжээ.

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР

